



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 287

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчийн 2018 оны 02-07-103/758 дугаар дүгнэлтээр тогтоогдсон 8,692,010.00 (найман сая зургаан зуун ерэн хоёр мянга арван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг буулгаж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал М.Түмэнжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг буулгаж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Үл хөдлөх хөрөнгийг буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албаны зориулалтаас өөр хэлбэрээр ашиглахгүй байх;

2.4. Үл хөдлөх хөрөнгийг буулгаж, ашиглаж болох эд зүйлийг ялган тоолж, худалдан борлуулах;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА



0000541

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
2019 оны 07 дугаар сарын 23-н
28.7 дугаар тогтоолын



"Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" төрийн өмчит үйлдвэрийн газрын
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах үл хөдлөх хөрөнгийн жагсаалт

Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлд /төгрөг/
Х	1980.04.05	м2	133	8,692,010.00	8,692,010.00	8,692,010.00	
Нийт дүн				8,692,010.00 (найман сая зургаан зуун ерэн хоёр мянга арван)	8,692,010.00 (найман сая зургаан зуун ерэн хоёр мянга арван)	8,692,010.00 (найман сая зургаан зуун ерэн хоёр мянга арван)	